

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМОНХ



БАТЛАВ  
СҮҮХҮНГИЙ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Э.БАТХУЯГ



### КОМПЬЮТЕР ТҮҮНИЙ ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар №.. 57/2022

20<sup>22</sup> оны 05-р сарын 09 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх негөө талаас Сүүхүнгий ХХК-ийг төлөөлж захирал Э.Батхуяг /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалт, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ”гэх) байгуулав.

#### Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь ”Компьютер түүний дагалдах хэрэгсэл” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

#### Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 14 /арван дөрөв/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

#### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1. Энэ гэрээний нийт үнэ 82,588,000 /наян хоёр сая таван зуун наян найман мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2. Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3. Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан баримт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 90 /ер/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5003348222 тоот дансанд шилжүүлнэ.

#### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.2. Захиалагч нь барааны бүрэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн ТУСП инженер А.Батзаяа хариуцан ажиллана. Утас- 99063759.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Сүүхүнгий ХХК-ийн захирал Э.Батхуяг хариуцан ажиллана. Утас- 99115078.

#### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэхээс хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон чанар стандартад нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш **12** сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг баталгаат хугацаанд өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

#### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1. Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцнө.

#### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 8.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

#### **Ес. Бусад нөхцөл**

- 9.1. Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Гэрээг Монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**  
 АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
 АЖ АХУЙ, ХАНГАМЖ ЭРХЭЛСЭН  
 ДЭД ЗАХИРАЛ  
 Б.УРТНАСАН  
 Гарын үсэг:

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
 НЯГТЛАН БОДОГЧ  
 Ө.УДВАЛ  
 Гарын үсэг:

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
 Г.ЭРДЭНЭБИЛЭГ  
 Гарын үсэг:

НЭГДСЭН ЦЕХИЙН ДАРГА  
 Ж.АРИУНЖАРГАЛ  
 Гарын үсэг:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
 Г.САРУУЛ  
 Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
 ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН  
 Ш.ГАНТУЛГА  
 Гарын үсэг:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
 хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
 Утасны дугаар: 77111251  
 РД: 6021646

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**  
 УЛААНБААТАР ХОТ  
 СҮҮХҮНГИЙ  
 ХХК-ИЙН ЗАХИРАЛ СҮҮХҮНГИЙ  
 Э.БАТХУЯГ ХХК  
 Гарын үсэг:

Хаяг: УБ хот ЧД 2-р хороо Canon төв 802 тоот  
 Утас: 99115078  
 РД: 5175968

**Тоот гэрээний хавсралт**

**НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ ЖАГСААЛТ**

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Суурин компьютер	Техникийн тодорхойлолт ын дагуу	Малайз	12	2,850,000	34,200,000	3,420,000	37,620,000
Зөөврийн компьютер	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	3	3,900,000	11,700,000	1,170,000	12,870,000
Зөөврийн компьютер	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	1	3,900,000	3,900,000	390,000	4,290,000
Зөөврийн компьютер	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	2	2,500,000	5,000,000	500,000	5,500,000
Компьютерийн дэлгэц	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	1	570,000.	570,000	57,000	627,000
Компьютерийн гар	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	10	25,000	250,000	25,000	275,000
Компьютерийн камер	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	6	65,000	390,000	39,000	429,000
Компьютерийн хулганы падь	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	10	5,000	50,000	5,000	55,000
Компьютерийн чихэвч	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	15	40,000	600,000	60,000	660,000
Компьютерийн гар	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	4	45,000	180,000	18,000	198,000
Компьютерийн хулгана	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	4	45,000	180,000	18,000	198,000
Утасны аппарат	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	4	150,000	600,000	60,000	660,000

Хатуу диск	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	3	180,000	540,000	54,000	594,000
Цаг бүртгэлийн машин	Техникийн тодорхойлолт ын дагуу	АНУ	4	520,000	2,080,000	208,000	2,288,000
Свич	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	5	50,000	250,000	25,000	275,000
Свич	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	2	600,000	1,200,000	120,000	1,320,000
Сүлжээний кабель толгой	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	100	200	20,000	2,000	22,000
Сүлжээний кабель холбогч /RJ45/	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	20	1,500	30,000	3,000	33,000
Принтер /өнгөт/	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	3	3,600,000	10,800,000	1,080,000	11,880,000
Принтер /өнгөт/	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	1	1,150,000	1,150,000	115,000	1,265,000
Скайннер	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	1	1,200,000	1,200,000	120,000	1,320,000
Дуу хураагч	Техникийн тодорхойлолт ын дагуу	БНХАУ	1	190,000	190,000	19,000	209,000
<b>Нийт үнэ</b>							<b>82,588,000</b>

Баталгаат засварын хугацаа: 1 жил

Амгалан дулааны станц ТӨХК-ийн  
Нэгдсэн цехийн дарга *Ж.Ариунжаргал*

Сүүхүнгий ХХК-ийн  
захирал *Э.Батхуяг*

